


Австрали уул уурхайгаас гадна боговсролын салбарасаа их мөнгө босгодог гэв

Австралийн Үндэсний Их Сургууль, Монгол Улсын Их Сургуультай хамтран "Mongolia Update" буюу Монголын орчин үеийн эдийн засаг, улс төр, нийгмийн асуудлын талаарх нээлттэй илтгэлийг правдахь удаагаатенилцуулж байна. Австралийн Үндэсний Их Сургууль дахь Монгол судлалын хүрээлэн хоёр жил тутам тус арга хэмжээг зохион байгуулдаг. Үгээр Австралийн Засгийн газар, бизнесийн байгууллага, эрдэмтэн судлаач, ард иргэдэд Монголын хамгийн сүүлийн үеийн мэдээллийг өгөх зорилготой аж. Энэ удаагийн нээлттэй илтгэл анх удаагаа Монголд болж байгаа гэнэ. Тус илтгэлд Австрали улсаас Монгол улсад суугаа онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд Жон Лантри, мөн НҮБ-д Монгол улсыг төлөөлж байсан Ж.Энхсайхан, Боловсрол соёл, шинжлэх ухаан, спортын дэд сайд Е.Отгонбаяр, Австрали улс дахь Монголын элчин сайд асан Р.Болд, Монгол улсын Ерөнхий сайд асан Р.Амаржаргал, УИХ-ын гишүүн асан С.Оюун, Гадаад хэргийн сайдын зөвлөх О.Машбат зэрэг улс төрч, судлаачид өнөөгийн улс төр, нийгэм, эдийн засаг, Үндэсний аюулгүй байдлын талаар сонирхолтой илтгэл тавьсан юм.

Уг үйл ажиллагааг нээж Австралийн онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд Жон Лантри "Манай хоёр улсын хооронд маш их боломж харагдаж байгаа. Бид зөвхөн улс төр, эдийн засгийн асуудлаар арихаас гадна, байгаль орчинд нөлөөлж байгаа зүйлсийн талаар ярилцлаа. Эдгээр асуудлууд Монгол, Австрали хоёрын хооронд зайлшгүй



ирэх болгомжтой. Өмнө нь ногооноор явбал илүү өртөг өндөртэй гэж болдог байсан бол одоо илүү ашигтай болж байна. Хүрнээс ногоон руу үерэнгүй хөгжвөл дэлхийд ч улс орондоо ч хэрэгтэй болж бизнесийн хувьд илүү ашигтай зам нээгдэнэ. Мэдээж бид эхлээд гэрийн даалгавар хийж техник технологи судлах хэрэгтэй" хэмээн ярьсан юм.

Мөн тэрээр "Австралийн

болгосон талаар "Одоохондоо энэ шийдвэрийг зөв, буруу гэж хэлэхэд хэцүү байна. Тодорхой загвар боловсруулж, олон хувилбарыг судалж байгаад шийдвэр гаргасан байх гэж бодож байна. Тэнгэр лүү зөвөл тааз руу харж байгаад гаргасан шийдвэр биш байх гэж горьдож байгаа. Сүүлийн үед америк доглогчид харьцах хэлбэлгэл нэлээд идэвхитэй лээн үйлдвэрлэж байна"

Эдийн засгийн асуудлаар ярихаас гадна, байгаль орчинд нөлөөлж байгаа зүйлсийн талаар ярилцлаа. Эдгээр асуудлууд Монгол, Австрали хоёрын хооронд зайлшгүй байх ёстой хэлэлцээр юм. Лагаад гавал бид гурав дахь хөршийн сайн харилцаатай. Монголчуудын гадаад хэлсүрч, дээд боловсрол эзэмшихээр явж байгаа хоёрдогч улс нь Австрали, Австралийг зорин явж байгаа монголчуудын тоо нэмэгдэж байгаа энэ үед уг уулзалт маш чухал арга хэмжээ болж байна" гэв.

УИХ-ын гишүүн асан С.Оюун илтгэлдээ "Тадныхан Монголын байгаль орчинд тулгамдаж байгаа асуудлуудын талаар маш их сонирхдог. Мэдээж улс болгон хөгжих ёстой ч байгальдаа ээлтэй хөгжих ёстой, Жишээ нь, манай говьд усны хомсболтой ч гол уурхайнууд бий. Тэгэхээр байгалиа хамгаалаад эдийн засгаа ч хөгжүүлэх арга замыг хайж байна. Монгол Улс Ногоон хөгжлийн бодлогоо хоёр жилийн өмнө баталсан. Сая Тогтвортой хөгжлийн бодлого баталлаа. Зүгээр бодлого батлаад цаасан дээр үлдээх бус хүрэн биш ногоон замаар цаашдаа яамаар байна. Энэ талаар оролдогуудыг хийж байгаагийн нэг нь сэргээгдэх эрчим хүчийг Монгол Улс дамжиж ажиллаж буй хэрэг. Улаанбаатарын агаарын бохирдолтой холбоотой барилтын дулаан алдагдлыг бууруулах төрөл бүрийн урамшууллыг гаргаж ажиллах ёстой. Бид байшин барьчихаад уурын зуухаар халаагаад хүрэн нүүрс хэрэглээд байдаг. Үүнийг халах хэрэгтэй. Ногооноор буюу сэргээгдэх эрчим хүчээр амьдаръя. Ногоон барилта барихад бидэнд хүү багатай зээл, техник эдийн засгийн бүцэлтгүй тусламж орж ирэх боломжууд нээгдэнэ. Манай улс сэргээгдэх эрчим хүчээр 2020 он гэхэд 20 хувь, 2030 он гэхэд 30 хувь хангахаар бодлогодоо тусласан. Өнгөрсөн жил Эрчим хүчний яам дэлхийн уур амьсгалын сангаас 30 сая долларын бүцэлтгүй тусламж авсан.

Монголын эдийн засаг хэцүү байгаа энэ үед ногоон чиглэлээр хөгжлөө тодорхойлох юм бол бидэнд гаднаас зээл тусламж

болж бизнесийн хувьд илүү ашигтай зам нээгдэнэ. Мэдээж бид эхлээд гэрийн даалгавар хийж техник технологи судлах хэрэгтэй" хэмээн ярьсан юм.

Мөн тэрээр "Австралийн хувьд уул уурхайн дараа орох салбар нь боловсролын салбар. Тэд боловсролын салбараасаа их мөнгө босгодог. Гадаад оюутнуудыг Австралид ихээр суралцуулаад түүгээрээ валют олж байна. Бид ч гэсэн уул уурхайгаас орж ирэх жаахан орлогоо боловсрол, хөдөө аж ахуй зэрэг салбаруудад оруулж эдийн засгаа солонгоруулах замаар явбал хөгжинэ. Уул уурхай хамгийн том салбаруудын нэг нь байсан бол түүнээс ч том салбар нь боловсрол болчихоод байна" гэлээ.

Боловсрол соёл, шинжлэх ухаан, спортын дэд сайд Е.Отгонбаяр "Ерөнхий боловсролын салбарт хөтөлбөр шинэчлэгдэж Кембрийжийн хөтөлбөр хэрэгжиж байгаа. Энэ жил аравдугаар английн сургалтын хөтөлбөр шинэчлэгдэнэ. Улсын их хурлаас батлагдсан боловсролын салбарт төрөөс баримтлах бодлого 2018 он, 2019 онд уг хөтөлбөрөөр дуусна. Судалгаа хийсний үндсэн дээр хөндлөнгийн үнэлгээ амжилттай, сайн яваа гэж үр дүн гарвал манай улсын ерөнхий боловсролд зааж байгаа хичээл олон улсын стандартад нийцсэн сургалттай гэгдэх юм. Энэ нь тавдугаар английн математикийн хичээлд олон улсад юу үзэж байна манай оронд яг ижил түвшинд сурах юм. Үүнд чанарын шинэчлэл гарах учраас ерөнхий боловсролыг 10 жил суралцдаг байсныг бид 12 жилийн програмид шилжүүлсэн. Үүний үр дүн удахгүй гарах байх. Мөн бид аль нэг их, дээд сургуулийг Азийн шилдэг их сургуульд багтаахаар ажиллаж байна. Үүнээс гадна гадаад улсын их дээд сургуультай хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх, хамтарсан дипломын сургалт явуулах зэрэг үйл ажиллагаа явуулж байна" гэв.

Мөн Монгол Улсын Ерөнхий сайд асан Р.Амаржаргал Монголбанкны захирлуудын зөвлөл өчигдөр хуралдаж бодлогын хүүг 10.5 хувиас 4.5 нэгж хувиар нэмэгдүүлж 15 хувь

оодож байна. Тэнгэр лүү эсвэл тааз руу харж байгаад гаргасан шийдвэр биш байх гэж горьдож байгаа. Сүүлийн үед америк доллартай харьцах хэлбэлзэл нэлээд идэвхитэй дээш, доош хэлбэлзэж байна. Үүнтэй холбоотой гадуур тодорхой хэмжээний хүлээлт үүссэн гэж бодож байгаа. Монгол Банк, Сангийн яам мөн ялгаагүй эдийн засгийн хүлээлтийг залж, чиглүүлэхдээ их муу. Тэр болгон залж чаддаггүй. Ханшийн хэлбэлзэл ийм хүчтэй байгаа нь нэлээд сөрөг гэж хэлэхээр нөхцөл байдалтай байна. Үүнд улс төрийн учир шалтгаан бас байгаа байх. Тэр бүгдийг бодолцож ийм алхам хийсэн юм болов уу гэсэн сэтгэгдэл надад төрж байна. Мөн долларын ханш, төгрөгийн ханшийн хэлбэлзэл ямар байгааг харж ийм шийдвэр гаргалаа гэж бодож байна. Энэ нь урт хугацаанд ямар үр дагавартай, дунд хугацаандаа ямар үр дагавартай байж болох талаар бид одоохондоо хэлэхэд хэцүү байна. Ямар ч байсан төгрөгөө үнэтэй болгоно. Төгрөгийн үнэ ханшийг нэмэгдүүлэхийн тулд төгрөгийнхөө нийлүүлэлтийг багасгъя гэсэн чиглэл рүү явууллаа. Тэгэл энэ бүхэн бодит эдийн засгийн сектор руугаа чухам яаж нөлөөлөх бол. Жишээ нь хөдөө аж ахуйн салбар болоод бусад эдийн засгийн салбарт ямар үр дагавартай гэдгийг бодох ёстой" гэлээ.

Мөн тэрээр "2017 онд эдийн засаг дээрлэх үчиртэй гэсэн хүлээлт байгаа. Саяхан гаргасан үзүүлэлтээр хэрэглэгчдийн индекс, үйлдвэрлэгчдийн индексийг харж байхад эдийн засаг дээшлэх хандлага ажиглагдсан. Энийгээ бид хадгалж чадах уу гэдэгт Сангийн яамнаас гаргах бодлогууд ихээхэн хэмжээгээр нөлөөлөх байх. Тун удахгүй төсвийн тодотгол орж ирнэ. Ямархуу төсвийн тодотгол орж ирэхийг мэдэхгүй байна. Мөн Монгол Банк, Сангийн яам хоёр нэг долгион дээр хамтран ажиллаж чадах уу. Тус тусдаа бие биенийгээ чирээд явах уу гэдэг нь бас л сонин үзэгдэл болоод байна. Энэ бүгдийг тооцоолж ажиллах хэрэгтэй байна" хэмээсэн юм.

САРИУНЖАРГАЛ

W